



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/270

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Манхан сумын харьяат Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар Цэндийн Олзвойн мэндэлсний 105 жилийн ойг тохиолдуулан Ардын жүжигчин Д.Гомбосүрэнгийн цомнол "Олзвой баатар" бүжгэн жүжгийг сэргээн туурвихад 20,0 сая төгрөгийг зарцуулсугай.

2. Уг арга хэмжээнд шаардагдах 20,0 сая төгрөг /Хорин сая/-ийг Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 5.1-д заасан хөтөлбөрөөс тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ

